

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ 2012 ОНЫ
11 ДҮГЭЭР САРЫН 06-НЫ ӨДРИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛЭЭР
ӨГӨГДСӨН ҮҮРЭГ, ДААЛГАВРЫН ХЭРЭГЖИЛТ**

(2013 оны 5 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар)

1. Санхүүгийн секторын тогтвортой байдлыг хангах бодлого, үйл ажиллагаагаа тогтмолжуулах уялдуулах, улирал бүр тогтвортой байдалд нь үнэлгээ дүгнэлт хийх. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан санхүүгийн секторын шинэчлэлийг хэрэгжүүлэх бодлого, арга хэмжээний талаар хагас жил тутам УИХ-д танилцуулга ирүүлж байх.

Төрөөс мөнгөний бодлогын талаар 2013 онд баримтлах үндсэн чиглэлд Санхүүгийн салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх хүрээнд банкуудын өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг нэмэгдүүлэн салбарын эрсдэл даах чадварыг дээшлүүлэх, банкны салбарын эрсдэлийн үнэлгээнд суурилсан хяналт шалгалтыг боловсронгуй болгох, банкны зээлийн барьцаа хөрөнгийн эрх зүйн орчныг шинэчлэх зэрэг бодлогын зорилтыг тусган хэрэгжүүлж байна. Энэ хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, банкны салбарын тогтвортой байдлын талаарх мэдээллийг Монголбанк УИХ-ын Эдийн засгийн байнгын хороонд улирал бүр тогтмол хүргүүлж, бодлогын арга хэмжээний хэрэгжилтийг тайлагнаж байгаа болно.

Банкны салбарын тогтвортой байдлыг бэхжүүлэх, банкуудын чадавхийг сайжруулах зорилтын хүрээнд Монголбанкнаас банкуудад хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 16.0 тэрбум төгрөгт хүргэх шаардлагыг 2011 онд тавьсан билээ. Энэхүү шаардлагыг хангаагүй байсан цөөн банкинд шаардлагыг биелүүлэхэд нь нэмэлт хугацаа олгосон бөгөөд холбогдох үүрэг даалгавар өгч, биелэлтэд хяналт тавин ажиллаж байна.

Монголбанкнаас системийн нөлөө бүхий банкуудад өөрийн хөрөнгийн шаардлагыг нэмэгдүүлсэн, банкуудын дүрмийн сангийн хэмжээг хоёр дахин өсгөсөн зэрэг шийдвэр гаргасан нь банкны системийн хэмжээнд өөрийн хөрөнгийн зохистой харьцаа энэ оны 1 дүгээр улирлын байдлаар 15.4 хувь болж 2012 оны мөн үеэс 0.2 нэгж хувиар өсөхөд эергээр нөлөөлөв.

Банкин дахь мөнгөн хадгаламжид баталгаа гаргах тухай хуулийн үйлчлэлийн хугацаа дууссан хэдий ч, хязгаарлагдмал хадгаламжийн даатгалын тогтолцоог бий болгох хууль эрх зүйн орчинг бүрдүүлсэн нь санхүүгийн тогтвортой байдлыг бэхжүүлэхэд ихээхэн дэмжлэг болсон.

Банкны салбарт итгэх итгэл бэхжиж байна. Тухайлбал, иргэдийн хугацаатай хадгаламж 2013 оны 1 дүгээр улирлын байдлаар 2.7 их наяд төгрөгт хүрч жилийн 24.1 хувиар, нийт хадгаламж 5.2 их наяд төгрөгт хүрч 20.2 хувиар тус тус өслөө. Банкны салбарын нийт активын хэмжээ мөн хугацаанд 12.5 их наяд төгрөгт хүрч өмнөх улирлаас 9 хувиар, өмнөх оны мөн үеэс 35.6 хувиар нэмэгджээ. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа 40.7 хувьд хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 3.9 нэгж хувиар сайжирсан үзүүлэлттэй байна. 2013 оны 1 дүгээр улиралд зээлийн үлдэгдэл 7.2 их наяд төгрөгт хүрч, жилийн 28.8 хувийн өсөлттэй гарав. Зээлийн энэхүү өсөлтөөс үл шалтгаалан банкуудын чанаргүй зээлийн харьцаа 2.3 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар сайжраад байна.

Банкуудын зээлийн эрсдэлийг бууруулах ажлын хүрээнд Монголбанк банкуудад хийх шалгалтын давтамжийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ төвлөрөл ихтэй, холбогдох этгээдийн зээлүүдийг шалгахад илүү анхаарал хандуулж, тогтоосон хязгаарлалтуудыг зөрчсөн тохиолдолд хууль тогтоомжид заасны дагуу арга хэмжээг авч ажиллав. Түүнчлэн, системийн хэмжээнд болон тухайн банкны хувьд төлбөрийн чадварын хүндрэл гарах

тохиолдолд авах арга хэмжээний бэлтгэлийг хангах зорилгоор болзошгүй хямралын үед авч хэрэгжүүлэх төлөвлөгөөг банк тус бүрээр гаргуулж байна.

Банкны үйл ажиллагааны зохистой харьцааг “Базел III” стандарттай уялдуулах хүрээнд уг стандартыг нэвтрүүлж буй олон улсын туршлагын талаар судалгаа хийж байна. Банкны засаглалын түвшинг үнэлэх журмын төслийг боловсруулж, холбогдох байгууллагуудаас санал авч тусгасан бөгөөд уг журмыг батлуулахаар ажиллаж байгаа болно. Банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор банкны нэгдэлд хийх нэгдсэн хяналт шалгалтын эрх зүйн орчинг сайжруулах журмын төслийг боловсруулж, зарим банк, санхүүгийн байгууллага дээр туршсан болно.

Зээлдэгчийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг банкны системийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ тооцох, түүний ачааллыг бууруулах, эрсдэл багатай зээлдэгчид бага хүүтэй зээл олгох бололцоо бүрдүүлэх зэрэг үйл ажиллагаанд ашиглах боломжийг судалж байна.

Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөс хагас жил тутамд Санхүүгийн тогтвортой байдлын тайланг гарган УИХ-ын гишүүд, олон нийтэд хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргэж байхаар шийдвэрлэсэн. Энэхүү тайлангийн анхны дугаар болох “Монгол Улсын Санхүүгийн тогтвортой байдлын тайлан 2012”-ын төслийг боловсруулсан бөгөөд 6 дугаар сард багтаан нийтэд түгээхээр ажиллаж байна.

Санхүүгийн тогтвортой байдлын тайлан нь банкны салбарт илүүтэй төвлөрөхөөс гадна санхүүгийн бусад байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн системийн тогтвортой байдлын талаарх өргөн хүрээтэй асуудлыг хамрах юм. Тухайлбал, макро-санхүүгийн дотоод болон гадаад орчин, санхүүгийн байгууллагын үйл ажиллагаа, санхүүгийн тогтвортой байдалд нөлөөлж болзошгүй эрсдэлт хүчин зүйлс, санхүүгийн дэд бүтэц, түүний институци зэрэг асуудлыг энэхүү тайланд тусгасан болно.

2. Хүн амын хэрэглээний гол нэрийн барааны үнэ бүрдэлтийн замын зургийг нийлүүлэлтийн гинжин хэлхээний үе шат бүрт нарийвчлан гаргаж, нийлүүлэлтийн саад хязгаарлалтуудыг арилгах, тогтвортой байдлыг хангах замаар үнийг тогтворжуулах иж бүрэн арга хэмжээ авч, хэрэгжүүлэх.

Нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг гарал үүслийн түвшинд нь багасгах, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн саад хязгаарлалтуудыг арилгах, нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах замаар гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулж, улмаар зах зээлийн зарчимд суурилсан, бараа бүтээгдэхүүний нийлүүлэлтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэхийг зорьсон цогц арга хэмжээг Монголбанк Засгийн газартай хамтран хэрэгжүүлж байна.

Тухайлбал, “Гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дунд хугацааны хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх харилцан ойлголцлын санамж бичиг”-ийг 2012 оны 10 дугаар сарын 22-ны өдөр баталж, энэ хүрээнд “Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр (FPS)”, “Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр (SIFS)”, “Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах дэд хөтөлбөр (TLF)”, “Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр (HPS)”-ийг тус тус хэрэгжүүлж байгаа болно.

Эдгээр дэд хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүнд 2012 оны 4 дүгээр сард Улаанбаатар хотын жилийн инфляцийн 52.2 хувийг хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт нь дангаар бүрдүүлж байсан бол 2013 оны 4 дүгээр сард 37.8 хувь болж буураад байна. Ийнхүү хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлт саарч байгаа нь жилийн инфляци мөн хугацаанд 2 дахин буурч 9.8 хувьд хүрэхэд нөлөөллөө.

- **“Хүнсний гол нэрийн бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” (FPS) дэд хөтөлбөр**

Махны нөөц бүрдүүлэх, үнийг тогтворжуулах: Монголбанкнаас оролцогч банкуудаар дамжуулан хөтөлбөрийг хэрэгжүүлэх үүрэг бүхий, Засгийн газартай гэрээ байгуулсан хуулийн этгээдэд олгосон 87.0 тэрбум төгрөгийн санхүүжилтээр нөөцийн менежер компаниуд Улаанбаатар хотод сертификатаар баталгаажсан нийт 9338.9 тонн, Дарханд 1025.1 тонн, Эрдэнэтэд 1016.1 тонн, нийт 11,380.1 тонн махны нөөцийг бүрдүүлсэн. Үүнээс 2013 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар нийт 6273.7 тонн мах буюу бэлтгэсэн нөөцийн 55 хувийг зах зээлд борлуулжээ.

Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээдүүд борлуулалтын орлогоос 16.3 тэрбум төгрөгийн зээлийг банкуудад, банкуудаас Монголбанкинд эргүүлэн төлөөд байна. Мөн ашиглаагүй байсан зээлийн үлдэгдэл болох 22.5 тэрбум төгрөгийг Монголбанк банкуудаас эргүүлэн татсан болно. Ингэснээр 2013 оны 5 дугаар сарын байдлаар хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээдүүд банкуудад нийт 48.2 тэрбум төгрөгийн зээлийн өрийн үлдэгдэлтэй байна.

Дэд хөтөлбөрийн үр дүнд мах, махан бүтээгдэхүүний дундаж үнийн өсөлт нь хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.7 дахин бага байлаа.

Гурилын үнийг тогтворжуулах: Энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гурилын үйлдвэрүүд үр тарианы нөөцөө барьцаалж эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл авах, агуулахын үлдэгдлээр баталгаажих санхүүгийн хэрэгслүүдийг нэвтрүүлж, хүнсний бүтээгдэхүүний хангамжийн зах зээлд суурилсан байнгын тогтолцоо бүрдэх юм. 2013 оны 5 дугаар сарын байдлаар хөтөлбөрт оролцогч банкууд Засгийн газартай гэрээ байгуулсан 22 гурилын үйлдвэрт 42.0 тэрбум төгрөг (зээлийн шугамын 68.9 хувь)-ийн хөнгөлөлттэй санхүүжилт олгожээ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэгч хуулийн этгээдүүд зээлийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу 894 сая төгрөгийн зээлийг банкуудад, банкуудаас Монголбанкинд буцаан төлсөн байна. Ингэснээр банкуудаас олгосон зээлийн үлдэгдэл 41.1 тэрбум төгрөг болов.

Энэхүү дэд хөтөлбөрийн гол зорилт болсон 1 дүгээр гурилын үнэ зах зээлд маш тогтвортой байгаа бөгөөд хөтөлбөр хэрэгжсэн хугацаанд 1.7 хувиар л өсчээ.

- **Шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтворжуулах (SIFS) дэд хөтөлбөр**

Монголбанк нь жижиглэнгийн зах зээлд худалдаалагдах шатахууны импортыг Монголбанкнаас тогтоосон хүүгээр санхүүжүүлэх, валютын ханшийн өөрчлөлтөөс хамаарах нөлөөллийг бууруулах замаар шатахууны жижиглэнгийн худалдааны үнийг тогтвортой байлгах зорилготой SIFS дэд хөтөлбөрийг 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн Уул уурхайн яамтай хамтран хэрэгжүүлж байна.

Дэд хөтөлбөрийн хүрээнд 2013 оны 5 дугаар сарын байдлаар оролцогч банкууд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч 12 компанид 190.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгосны зэрэгцээ 384.8 тэрбум төгрөгтэй тэнцэх ам.долларыг 2-6 сарын дараа худалдах нөхцөлтэй форвард хэлцэл хийгдсэн байна.

Дээрх арга хэмжээний үр дүнд хөтөлбөрийг хэрэгжүүлэгч компаниуд жижиглэнгийн нефтийн бүтээгдэхүүнээ хямд зардлаар санхүүжүүлж, зээлийн хүүнээс шалтгаалсан өртгөө бууруулах нөхцөл бүрдсэний зэрэгцээ нефтийн төлбөр тооцоо гүйцэтгэхтэй холбоотой ханшийн эрсдэлийг бууруулсан байна.

Түүнчлэн, тус хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрэв:


- Засгийн газрын 126 дугаар тогтоолын үр дүнд компаниудын газрын тосны бүтээгдэхүүний нөөц 2013.05.28-ны өдрийн байдлаар хөтөлбөрийг эхлүүлсэн үетэй харьцуулахад 2.4 дахин нэмэгдэж, нийлүүлэлтийн тасралтгүй байдал хангагдсан.
- Хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагаанд ашиглах зорилгоор импортолсон автобензин, дизелийн түлшинд татвар ногдуулах эрх зүйн орчинг бүрдүүлсэн (Засгийн газрын 2012.11.23-ны өдрийн 134 дүгээр тогтоол).
- “Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль” болон “Газрын тосны бүтээгдэхүүний тухай хууль”-д нэмэлт өөрчлөлт оруулж, жижиглэнгийн худалдааг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэх эрх зүйн орчинг бүрдүүлсэн.
- Шатахуун борлуулагч аж ахуйн нэгжүүд болон төрийн байгууллага хоорондын ажлын уялдаа сайжирсан.
- Газрын тосны бүтээгдэхүүний нийлүүлэлтийн эх үүсвэрийг төрөлжүүлэх ажлын хүрээнд Засгийн газар БНХАУ-ын “Чайна Ойл” ХХК-тай гэрээ байгуулж, сар бүр 10 мянга хүртэл тонн шатахуун худалдан авахаар болсны зэрэгцээ БНСУ-ын SK Energy компаниас шатахуун худалдан авах чиглэлд ажиллаж байна. Газрын тосны бүтээгдэхүүний импортын 27%-ийг ОХУ-аас бусад улсаас импортлох болж, импортын эх үүсвэрийг төрөлжүүлж байна.

Хүснэгт 1: Нөөцийн өөрчлөлт (мянган тонн)

Сар	Нийт	ДТ	П-95	АИ-92	А-80
2012.1	33.2	13.1	-	10.4	9.7
2012.11	45	10.1	-	19.9	15
2012.12	67.4	22.7	1.3	28.3	15.2
2013.1	114.9	53.9	3.8	37	20.2
2013.2	112	58.1	5	30.3	18.6
2013.3	92.8	49.3	4.2	21.5	17.8
2013.4	84	45.8	3.1	17.3	17.8
2013.5	81.3	44.1	3.2	17.8	16.1
2013.5/2012.10 өсөлт (дахин)	2.4	3.4	-	1.7	1.7

Эх сурвалж: Газрын тосны газар

Зураг 1: Газрын тосны бүтээгдэхүүний импорт



• **Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний өртгийг бууруулах (TLF) дэд хөтөлбөр**

Монголбанкнаас гадаад худалдааны тээвэр, логистикийн дэд бүтцийг сайжруулах замаар өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний нийлүүлэлтийн жигд тасралтгүй байдлыг хангах, үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор TLF дэд хөтөлбөрийг 2012 оны 10 дугаар сарын 26-ны өдрөөс эхлэн Зам, тээврийн яамтай хамтран хэрэгжүүлж байна.

Дэд хөтөлбөрт үндсэн 5 зорилтот ажлын хүрээнд холбогдох арга хэмжээг авахаар төлөвлөсөн бөгөөд 2013 оны 5 дугаар сарын байдлаар дараах биелэлттэй байна:

Зорилт 1: Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний ачаа эргэлтийг нэмэгдүүлж хурдасгах

- Өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний тээвэрлэлтийг тогтсон хуваарийн дагуу тусгайлсан 2 галт тэргээр гүйцэтгэж, ачаа эргэлтийг хурдасгалаа. Энэхүү арга хэмжээг 2012.10.29-ний өдрийн 09.00 цагаас эхлүүлж, 2013.05.31-ний өдрийн байдлаар 377 галт тэрэг, 21,873 вагоноор нийт 1,194,485.0 тонн өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүнийг Замын-Үүдээс Улаанбаатар хот хүртэл 24 цагт багтаан тээвэрлэсэн байна.
- 2013.04.08-ны өдрөөс эхлэн тусгай зориулалтын нэмэлт 1 галт тэргээр цемент тээвэрлэж эхлэв.

- Өргөн хэрэглээний импортын бараа, бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах, тээвэрлэлтийг тасралтгүй шуурхай зохион байгуулах зорилгоор Цагаан сарын баярыг угаж шуурхай арга хэмжээ авч ажилласан.

Зорилт 2: Ачаа тээвэрлэлтийн өртгийг бууруулах

Монгол-Оросын хувь нийлүүлсэн “Улаанбаатар төмөр зам” нийгэмлэгийн шатахууны эргэлтийн хөрөнгөд дэмжлэг үзүүлэх зорилгоор 2013.03.21-ний өдөр хөтөлбөрт оролцогч банкнаас 22.0 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон. Ингэснээр УБТЗ нийгэмлэг 994 мянган ам.доллар буюу 1.4 тэрбум төгрөгийн шатахууны зардлыг хэмнэсэн байна.

- УБТЗ нийгэмлэг нь өргөн хэрэглээний импортын бараа бүтээгдэхүүн, зорчигч тээвэрлэлт болон дотоодын нүүрсний тээвэрлэлтээс жилд 38 тэрбум төгрөгийн алдагдал хүлээж иржээ. Харин экспортын зарим бүлэг (зэс, цайрын баяжмал, төмрийн хүдэр, жонш, коксжих нүүрс)-ийн ачаа тээврийн тарифыг 5-25 хувиар нэмэгдүүлэхээр шийдвэрлэсэн нь уг алдагдлыг зохих хэмжээгээр бууруулж, өргөн хэрэглээний бараа, бүтээгдэхүүний үнийг тогтвортой байлгахад эерэгээр нөлөөлж байна.
- Тарифын бус зардлыг бууруулахад чиглэсэн удирдлага, зохион байгуулалт, хяналтын тодорхой ажлууд хэрэгжиж, УБТЗ нийгэмлэгийн бүтцийг шинэчлэх талаар санал боловсруулах Ажлын хэсэг байгуулан ажиллаж байна.
- Зардлыг бууруулах чиглэлээр төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллаж байна.

Зорилт 3: Тяньжин-Замын Үүд чиглэлийн ачаа тээвэрлэлтийг хөнгөвчлөх

- Монгол-Хятадын төмөр замын тээврийн салбарын хамтын ажиллагааг эрчимжүүлэх асуудлыг судалж, холбогдох арга хэмжээ авахаар Ажлын хэсэг ажиллаж байна.

Зорилт 4: Төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний паркийг нэмэгдүүлэх

- Шаардлагатай байгаа ачааны 400 хагас вагон, 60 битүү вагон, гол замын 3 зүтгүүр, сэлгээний 3 зүтгүүрийг 70 тэрбум төгрөгийн зээлээр худалдан авахаар судалгаа хийгдсэн. Нийгэмлэгийн Ерөнхий хорооноос гарах шийдвэр хүлээгдэж байна.
- Дулааны цахилгаан станцуудын хэрэгцээнд нүүрс тээвэрлэхэд зориулан 1000 вагон худалдан авах бэлтгэл ажлыг хангаж байна.

Зорилт 5: Ачааны терминалын хүчин чадлыг нэмэгдүүлэх

- Замын-Үүд дэх төмөр зам, авто замын ачаа тээврийн нэгдсэн терминалыг батлагдсан ТЭЗҮ-ийн дагуу өргөтгөх ажлын хүрээнд Зам тээврийн яам, Азийн хөгжлийн банкны хооронд 2013.04.29-ний өдөр байгуулсан Харилцан ойлголцлын санамж бичигт "Бүс нутгийн логистикийн төвийг хөгжүүлэх төсөл"-ийн “Битүү, задгай агуулахад сав баглаа боодолтой болон өргөн хэрэглээний бүтээгдэхүүнийг шилжүүлэн ачих, хадгалах байгууламж”-ийн санхүүжилтийг Засгийн газар шийдвэрлэхээр тусгасан. Уг санхүүжилтийг дэд хөтөлбөрийн эх үүсвэрээр шийдвэрлэх боломжийг судалж байна.
- Улсын хилийг Замын-Үүд терминал 3-тай холбосон автозамын барилгын ажлыг Хөгжлийн банкны санхүүжилтээр гүйцэтгэн, 2013 оны 6 дугаар сард ашиглалтад оруулахаар ажиллаж байна.

- **“Барилгын салбарыг дэмжих, орон сууцны үнийг тогтворжуулах (HPS) дэд хөтөлбөр”**

Тус хөтөлбөрийг Барилга, хот байгуулалтын яамтай хамтран 2013 оны 1 дүгээр сарын 9-ний өдрөөс эхлэн дараах үндсэн чиглэл, зорилттойгоор хэрэгжүүлж байна:

Барилгын гол нэр төрлийн материалын үнийг тогтворжуулах:

- a) Барилгын гол нэр төрлийн материалын дотоодын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах;
- b) Зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгах;
- c) Дэвшилтэт технологи бүхий, байгаль орчинд ээлтэй барилгын материал үйлдвэрлэх төслүүдийг дэмжих;
- d) Орон сууцны барилгын нийлүүлэлтийг дэмжих;

Орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох урьдач нөхцөл нь орон сууцны барилгын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх явдал юм. Иймд орон сууцны барилгын нийлүүлэлтийг дэмжих арга хэмжээг цогцоор нь авах шаардлага үүссэн.

Энэ хүрээнд Засгийн газартай гэрээ байгуулсан барилгын материал үйлдвэрлэгч дотоодын аж ахуйн нэгжүүдэд эргэлтийн хөрөнгийн хөнгөлөлттэй зээл авч үйлдвэрлэлээ өргөтгөх боломжийг олгох, барилгын гол нэр төрлийн материалын нийлүүлэлтийн тогтвортой байдлыг хангах зорилгоор 58.9 тэрбум төгрөгийг хөтөлбөрт оролцогч банкуудаар дамжуулан барилгын материал үйлдвэрлэгч дотоодын аж ахуйн нэгжүүдэд, зайлшгүй импортлох шаардлагатай барилгын материал (цемент, арматур)-ын улирлын шалтгаантай нийлүүлэлтийн хязгаарлалтыг арилгах зорилгоор 106.3 тэрбум төгрөгийг хөтөлбөрийг хэрэгжүүлэгч компаниудад тус тус олгоод байна. Барилгын салбарыг дэмжих, орон сууцны барилгын нийлүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор Монголбанк гэрээний үндсэн дээр банкуудад зөвхөн орон сууцны барилгын зээлд ашиглагдах 300 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг байршууллаа. Зээлийн энэхүү эх үүсвэрээс 30 орчим хувь нь зориулалтын дагуу буюу орон сууцны барилгын зээлд ашиглагдаад байна.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлснээр орон сууцны барилгын нийлүүлэлт нэмэгдэж, үнэ тогтворжих, улмаар орон сууцны ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бүрдүүлэх урьдач нөхцөл хангагдах юм.

Орон сууцны санхүүжилтийн урт хугацааны тогтвортой тогтолцоог бий болгох:

Ипотекийн санхүүжилтийн тогтвортой тогтолцоог бий болгох талаар хамтран ажиллах харилцан ойлголцлын санамж бичгийг Монголбанк Засгийн газартай 2013.04.13-ны өдөр байгуулсан бөгөөд шаардлагатай журам, гэрээг Засгийн газар, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос боловсруулж батлах ажил хийгдэж байна.

3. Эдийн засгийн өсөлт, түүний дотор жижиг, дунд бизнес, уул уурхайн бус экспорт болон эдийн засгийг солонгоруулах бодлогыг мөнгөний бодлогын бусад арга хэрэгслээр дэмжих, тухайлбал, гадаад зах зээлээс санхүүгийн хямд эх үүсвэр татаж арилжааны банкуудыг зээлжүүлэх, тэдэнд зээлийн нэмэлт эх үүсвэр бий болгоход нь баталгаа гаргах, бодлогын хүү, заавал байлгах нөөц зэргийн удирдлагыг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан уян хатан болгох, нээлттэй зах зээл дээрх ажилбаруудыг эдийн засгийн өсөлтийн зорилгод нийцүүлэх зэрэг үйл ажиллагааг шуурхай авч хэрэгжүүлэх.

Мөчлөг дагасан төсвийн тэлэлт, ирээдүйн экспортын орлогыг барьцаалсан богино хугацаатай зээлээр санхүүжүүлсэн нийгмийн хавтгайрсан халамж буюу бэлэн мөнгө тараалт, хууль эрх зүйн орчинд гарсан тодорхой бус байдал, төсвийн тэлэлт болон нийлүүлэлтийн хязгаарлалтаас үүдэлтэй өндөр инфляци нь 2012 онд Монгол Улсын дотоодын эдийн засгийн эрсдэлийг эрс нэмэгдүүлсэн. Ийм үед гадаад секторын эрсдэл нь гадаад худалдааны нөхцлийн муудалт, гадаадын шууд хөрөнгө оруулалтын бууралтаар дамжин дотоодын эдийн засагт сөргөөр нөлөөлснөөр мөнгө, зээлийн үзүүлэлтүүд саарч, эдийн засгийн бодит өсөлт удаашран, бодлогын урьдач арга хэмжээ авахгүй тохиолдолд

санхүүгийн болон макро эдийн засгийн тогтворгүй байдлыг бий болгох, улмаар хямралд ч өртөж болзошгүй нөхцөл байдлыг үүсээд байв.

Гэвч эдийн засгийн удаашралын мөчлөгийг сөрж, эрсдлээс урьдчилан сэргийлсэн макро бодлогыг хэрэгжүүлсний үр дүнд санхүүгийн болон макро эдийн засгийн харьцангуй тогтвортой суурийг бүрдүүлж, болзошгүй хямралын эрсдэлээс урьдчилан сэргийлэв.

Эрсдэлээс урьдчилан сэргийлсэн, мөчлөг сөрсөн макро бодлогын хүрээнд Монголбанкнаас бодлогын дараах арга хэмжээг хэрэгжүүллээ:


- “Гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнийг тогтворжуулах” хөтөлбөрийг Засгийн газартай хамтран хэрэгжүүлж, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн дарамтыг эрс бууруулж, эдийн засаг дахь бүтээмжтэй, тодорхой зорилго бүхий төгрөгийн нийлүүлэлтийг нэмэгдүүлэн, эдийн засгийн бодит секторт дэмжлэг үзүүлэв.
- Засгийн газартай байгуулсан “Санхүүгийн зуучлалын гэрээ”-ний хүрээнд Монгол Улсын гадаад валютын улсын нөөцөөр баталгаажсан төгрөгийг эдийн засагт нийлүүлж, банкуудад 900 тэрбум төгрөг (энэ нь “Чингис” бондын хөрөнгөнөөс тусдаа эх үүсвэр)-ийн хадгаламж байршуулав. Банкууд уг эх үүсвэрийг эдийн засгийн бодит секторт ажлын байр, үйлдвэрлэл, үйлчилгээг нэмэгдүүлэх зээл болгон гаргаснаар бизнесийн идэвхжилийг дэмжиж, эдийн засгийн бодит өсөлтөд дэмжлэг болж байна.
- Инфляцийн хэтийн хандлага нь зорилтот түвшинтэй нийцтэй, эрэлтийн шалтгаантай инфляцийн дарамт буурч, нийлүүлэлтийн гаралтай инфляцийн нөлөөлөл багасахаар хүлээгдэж байсан нь мөнгөний бодлогын хүүг бууруулах нөхцөлийг бүрдүүлсэн тул Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл 2013 оны эхнээс мөнгөний бодлогын хүүг 2 удаа, нийтдээ 1.75 нэгж хувиар бууруулан 11.5 болгов. Бодлогын энэхүү арга хэмжээ нь мөнгө, зээлийн өсөлтийг тогтворжуулах, санхүүгийн салбарын хэвийн үйл ажиллагааг хангах, зээл, хөрөнгө оруулалтыг урамшуулах, эдийн засгийн бодит сектор, бизнесийн идэвхжилтийг дэмжих ач холбогдолтой болсон.
- Дотоодын макро эдийн засгийн орчин, мөнгөний зах зээлийн хөгжлийн шаардлага, мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх олон улсын шилдэг туршлагад суурилан хүүний коридорыг шинээр нэвтрүүлэв. Ингэснээр богино хугацаат хүүг илүү үр дүнтэй удирдан, хэлбэлзлийг нь бууруулах, хүүний сувгийн нөлөөллийг сайжруулах, мөнгөний бодлогын хэрэгжилтийн ил тод байдлыг нэмэгдүүлэх, банк хоорондын зах илүү үр ашигтай ажиллах, Төв банкны үнэт цаасны хэмжээ буурах, Монголбанкнаас банкуудын авах санхүүжилтийн хүү буурах, эдийн засгийн идэвхжилд эерэгээр нөлөөлөх зэрэг олон талын ач холбогдолтой боллоо.
- “Гадаад худалдааг дэмжих, экспортыг урамшуулах механизмыг бий болгох замаар экспортын болон эдийн засгийн бүтцийг төрөлжүүлэх бодлогын санал”-ыг боловсруулж Засгийн газарт хүргүүлэн, тусгайлсан хөтөлбөр боловсруулах чиглэлд хамтран ажиллаж байна. Уг бодлогын саналд ашигт малтмалын бус салбарын экспортыг дэмжих механизм, институциональ бүтэц, санхүүжилтийн схемийг цогцоор нь шийдвэрлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг тусгасан болно.
- “Хөдөөг хөгжүүлэх, орон нутаг дахь бизнесийг дэмжих бодлогын санал”-ыг боловсруулж Засгийн газарт хүргүүлэн, тусгайлсан хөтөлбөр боловсруулах чиглэлд хамтран ажиллаж байна. Уг бодлогын саналд: (i) аймаг, сум бүрийн онцлог, давуу талыг судалсны үндсэн дээр тухайн орон нутагт “брэнд” бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээг хөгжүүлж, тогтвортой ажлын байр бий болгох, (ii) орон нутаг дахь суурь бүтцийн шаардлагатай хөрөнгө оруулалтыг хийх, (iii) орон нутаг дахь тээвэр, логистикийг хөгжүүлж, бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг бууруулах, (iv) орон нутагт ажиллахад Улаанбаатарт ажиллахаас илүү таатай нөхцөл (цалин урамшуулал, амьдрах нөхцөлийн оновчтой схем) бүрдүүлэх замаар хот руу ирэх урсгалыг багасгаж, хотоос орон нутаг руу чиглэсэн урсгалыг бий болгох, (v) орон нутаг дахь банк, санхүүгийн үйлчилгээний өртгийг бууруулах, шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ нэвтрүүлэх, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, иргэдийн санхүүгийн

боловсролыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг хамтад нь хэрэгжүүлэх замаар санхүүгийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн бодлого, арга хэмжээг тусгасан.

- Засгийн газрын үнэт цаасыг анхдагч болон хоёрдогч зах зээлд арилжаалах нөхцөлийг бүрдүүлж, арилжааг тогтмол зохион байгуулав. Ингэснээр улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх болон урт хугацааны зорилтот төсөл, хөтөлбөрийг эрсдэлийн боломжит түвшинд, хамгийн бага зардалтайгаар санхүүжүүлэх, Засгийн газрын үнэт цаасны зах зээл, улмаар хөрөнгийн зах зээлийг хөгжүүлэх, Засгийн газрын үнэт цаасны буюу төгрөгийн өгөөжийн муруйг бий болгох, төсөв, мөнгөний бодлогын харилцан уялдааг хангах зэрэг ач холбогдолтой байна.
- Холбогдох хууль эрх зүйн орчныг шинэчлэх арга хэмжээг хэрэгжүүллээ. Үүнд: Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль эрх зүйн шинэчлэл, Банкны зээлийн барьцаа хөрөнгөтэй холбоотой эрх зүйн шинэчлэл зэрэг болно.
- Төсвийн тогтвортой байдлыг тууштай хангасан орчинд мөнгөний бодлогоор эдийн засгийн бодит секторуудыг дэмжих, эдийн засагт дутагдалтай байгаа мөнгөний нийлүүлэлтийг санхүүгийн болон макро тогтвортой байдалтай уялдуулан хийх, ингэхдээ тодорхой зорилтот хөтөлбөрүүдийн хүрээнд эдийн засагт ажлын байр, үйлдвэрлэл, бүтээмж бий болгох, “бүтээмжтэй буюу зорилтот” төгрөгийн нийлүүлэлтийг хийх бодлогыг үргэлжлүүлж байна.
- Эдийн засагт урт хугацаатай төгрөгийн эх үүсвэр, хуримтлал (ипотекийн зээл)-ыг нэмэгдүүлж, санхүүгийн салбар дахь хэрэглээний шинжтэй зээлийг хумих бодлого баримтлан, улмаар үндэсний хэмжээнд хуримтлалыг урамшуулах замаар нийгмийн дундаж давхаргыг бэхжүүлж, эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийг хангах чиглэлд ажиллаж байна.

Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогын цогц арга хэмжээний үр дүнд банкны салбарын зээлийн жигнэсэн дундаж хүү 2012 оны 12 дугаар сард төгрөгийн хувьд 14.9 хувь болж өмнөх сараас 3.7 нэгж хувиар, валютын хувьд 12.2 хувь болж 1.1 нэгж хувиар тус тус буурч байв. 2013 оны 4 дүгээр сарын байдлаар төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү оны эхний сартай харьцуулахад 1.1 нэгж хувиар, өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 0.8 нэгж хувиар тус тус буурчээ. Экспортын орлого буурсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт татарсан, санхүүгийн салбар дахь гадаад цэвэр активын хэмжээ багассан, эх үүсвэрийн хомсдол бодитой нүүрлэж болзошгүй байсан эрсдэлтэй үед зээлийн жигнэсэн дундаж хүү ийнхүү буурах хандлагатай байгаа нь Монголбанкнаас хэрэгжүүлж байгаа мөнгөний бодлого, түүний хэрэгжилттэй шууд холбоотой байна.

Зураг 2: Банкны зээлийн жигнэсэн дундаж хүү (%)



Эх сурвалж: Монголбанк

4. “Зээлийн хүү буурах зах зээлийн орчин бүрдүүлэх” хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж 2013-2016 онд хэрэгжүүлэх, үр дүнг хагас жил тутамд УИХ-д танилцуулж байх.

Энэхүү хөтөлбөрийг 2011.11.23-ны өдөр Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайд, Санхүүгийн зохицуулах хороо (СЗХ)-ны дарга, Үндэсний хөгжил, шинэтгэлийн хороо (ҮХШХ)-ны даргын 677/229/188/142 тоот хамтарсан тушаалаар батлан хэрэгжүүлж байна. Хөтөлбөрт тусгагдсан зарим зорилтууд хэрэгжсэн хэдий ч, биеллээгүй болон дутуу гүйцэтгэлтэй зарим ажлуудыг холбогдох газрууд цаашид хэрэгжүүлэх шаардлагатай, зээлийн хүүг бууруулах чиглэлээр холбогдох байгууллагууд шинэ зорилт, арга хэмжээ хэрэгжүүлж эхэлж байгаа, хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлж байсан ҮХШХ нь Эдийн засгийн хөгжлийн яам (ЭЗХЯ) болж шинэчлэн зохион байгуулагдсан зэрэгтэй уялдан тус хөтөлбөрийг шинэчлэн боловсруулж, хэрэгжүүлэх хугацааг 2013-2016 болгон өөрчлөх шаардлага үүссэн.

Иймд, УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу хөтөлбөрт тусгах шинэ зорилт, зээлийн хүүг бууруулах чиглэлээр шинээр хэрэгжүүлэх арга хэмжээг хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд болох Сангийн Яам, ЭЗХЯ, СЗХ, Монголын Банкуудын холбооноос хүлээн авч хөтөлбөрт тусган, дунд хугацаанд хэрэгжүүлэх хөтөлбөрийн төслийг шинээр боловсруулах, холбогдох байгууллагуудаас санал авах шатанд байна.

5. Валютын ханшийн одоо үйлчилж буй дэглэмийн хүрээнд банк хоорондын зах зээлд оролцогчдын тоог нэмэгдүүлэх, хамрах хүрээг өргөжүүлэх чиглэлээр арга хэмжээ авч, төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь эдийн засгийн бүтцийн өөрчлөлтийн үйл явцтай нийцэж, эдийн засгийн оролцоотой өсөлтийг дэмжих зорилтод чиглэгдэж байхаар бодлогын цогц арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Гадаад валютын дотоодын зах зээлд валютын арилжаа хийх нөхцөл боломж нь банкууд, эрх бүхий банк бус санхүүгийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд, иргэнд нээлттэй буюу гадаад валютын дотоодын захад оролцогчдын тоог бууруулах нөлөөтэй аливаа хориг саад, хязгаарлалт байхгүй юм. Тухайлбал, иргэн, хуулийн этгээд нь валютын арилжааг бэлэн ба бэлэн бус хэлбэрээр, түүнчлэн валютын үүсмэл хэрэгслийн хэлцлийг тухайн үйл ажиллагааг эрхлэх эрх бүхий этгээдтэй чөлөөтэй хийж байгаа болно.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш нь макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр чөлөөтэй тогтож байна.


2013 оны эхний 4 сард экспортын орлого 5 хувиар, Монгол Улсад орж ирэх гадаадын шууд хөрөнгө оруулалтын цэвэр урсгал урьдчилсан гүйцэтгэлээр 37 хувиар тус тус буурсан зэрэг суурь хүчин зүйлс нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийг сулруулах чиглэлд нөлөөлснөөр 2013.05.31-ний өдрийн байдлаар төгрөгийн ам.доллартай харьцах ханш 1,442.2 төгрөг болж оны эхнээс 3.6 хувиар буюу 49.8 төгрөгөөр суларчээ. Энэ оны эхнээс ханшийн хандлагыг авч үзвэл төгрөгийн ам.доллартай харьцах ханш оны эхний 2 сард тогтвортой буюу дунджаар 1,393 төгрөг байсан бол 2 дугаар сарын сүүл үеэс эхлэн алгуур суларсан байна.

Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш ийнхүү макро эдийн засгийн суурь нөхцөлтэй нийцтэйгээр, зах зээлийн орчны өөрчлөлттэй уялдан чөлөөтэй тогтож, оны эхнээс алгуур сулрах хандлагатай болсон нь гадаад зах зээлийн эрсдэлийн дотоодын эдийн засаг дахь сөрөг нөлөөллийг ханшид шингээх замаар зөөлрүүлэх, дотоодын эдийн засаг, гадаад худалдаа, санхүүгийн зах зээл дэх зайлшгүй шаардлагатай тохиргоог хийлгэх, ингэснээр эдийн засгийн бодит өсөлтийг огцом сааруулахгүй байлгах, улмаар эдийн засгийн

идэвхжил эрс сулрах, болзошгүй хямралд өртөх эрсдэлээс сэргийлэх нөхцөлийг тус тус бүрдүүлж байгаа болно.

Монголбанкнаас хэрэгжүүлж буй мөнгөний бодлого, ханшийн талаар баримтлах зарчим, нээлттэй захын үйл ажиллагаа нь эдийн засгийн урт хугацааны тогтвортой өсөлтийн зорилтыг хангахад чиглэж байна. Уг зорилтод хүрснээр эдийн засгийн хүртээмжтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлэх юм.

Зураг 3: Төгрөгийн ам.доллартай харьцах Монголбанкнаас зарласан ханш




Эх сурвалж: Монголбанк

Энэ оны эхний 5 сард төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хэлбэлзэл маш бага буюу өдөрт хамгийн ихдээ 0.38 хувиар чангарч, 0.36 хувиар суларч, дундаж хэлбэлзэл нь 0.1 хувь байна.

Мөн хугацааны нийт өдрийн 87 хувьд нь ханшийн нэг өдрийн дундаж хэлбэлзэл 0.20 хувиас бага байсан нь төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн хэлбэлзэл маш тогтвортой байсныг харуулж байна.

Зураг 4: Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн нэг өдөрт ногдох дундаж хэлбэлзэл



Эх сурвалж: Монголбанк

Монголбанк төгрөгийн валюттай харьцах ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх чиглэлээр валютын захын үйл ажиллагаанд шаардлагатай үед оролцон зохицуулалт хийж байна. Тухайлбал, валютын эрэлт, нийлүүлэлтийн богино хугацааны, түр зуурын шинжтэй зөрүүг багасгах, ханшийн огцом хэлбэлзлийг зөөлрүүлэх зорилгоор тайлант хугацаанд 42 удаагийн дуудлага худалдааг зохион байгуулж, гадаад валютын захад 22 удаа оролцжээ.

6. Мөнгөний бодлогын шийдвэр гаргах үйл ажиллагааны бие даасан, хараат бус байдлыг хангах, Төв банкны засаглалын бүтцийг сайжруулах чиглэлээр холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах, санхүүгийн зах зээлд оролцогчдын санал бодлыг шийдвэр гаргах үйл явцад тогтмол тусгаж, бодлогын зөвшилцлийн механизмыг бүрдүүлж мөнгөний бодлогын хэрэгжилтийг олон нийтэд тогтмол тайлагнах замаар Төв банкны засаглал, хариуцлагыг сайжруулах.

Мөнгөний бодлогын бие даасан, хараат бус байдлыг хангах, бодлогын шийдвэр гаргах үйл явцыг сайжруулах чиглэлд гарсан чухал дэвшил нь 2012.10.26-ны өдөр Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөл (МБЗ)-ийг Монголбанкнаас томилогдсон 8 гишүүн, төрийн байгууллага, их сургууль буюу академи, хараат бус судлаачдыг төлөөлсөн 5 гишүүн, нийт 13 гишүүнтэйгээр шинээр байгуулсан явдал юм. Ингэснээр тус зөвлөл нь мөнгөний бодлогын саналыг батлагдсан журмын дагуу 3 удаагийн хуралдаанаар хэлэлцэж, асуудлыг тал бүрээс нь авч үзсэн мэтгэлцээний үр дүнд бодлогын шийдвэр гаргадаг, шийдвэрийг хэвлэлийн хурал, мөнгөний бодлогын мэдэгдлээр олон нийтэд нэн даруй мэдээлж, гаргасан шийдвэрийн үндэслэлийг тайлбарладаг, хуралдааны протоколыг нийтэд танилцуулдаг болов.

Түүнчлэн, Монголбанкнаас хэрэгжүүлж буй бодлогыг олон улсын болон дотоодын хурал, зөвлөгөөн, семинар, сургалтаар тайлбарлан таниулж, санхүүгийн зах зээлд оролцогчид, судлаачид, мэргэжлийн холбоод, төрийн бус байгууллагуудын санал, шүүмжийг хүлээн авч, бодлого, үйл ажиллагаандаа тусгаж байгаа болно. Мөнгөний бодлогын хэрэгжилтэд Төв банкны нээлттэй, ил тод байдал чухал үүрэгтэй тул Монголбанкнаас олон нийттэй харилцах үйл ажиллагааг сайжруулан, мөнгөний бодлогын хэрэгжилт, арга хэмжээг нийтэд ил тод, нээлттэйгээр тогтмол тайлагнах замаар иргэд, олон нийтийн зүгээс бодлогын арга хэмжээний үр дүнд итгэх итгэлийг бэхжүүлэн, зах зээлийн хүлээлтийг зохистой удирдан төлөвшүүлж байна.

Олон нийтийн мэдлэг, боловсролыг дээшлүүлэх зорилгоор Монголбанкнаас мөнгөний бодлогын үндсэн зорилт, чиглэл, үйл ажиллагаа, ил тод байдал, макро эдийн засгийн бодлого, бодлогын харилцан уялдаа зэрэг өргөн хүрээтэй асуудлаар цуврал сургалт, эрдэм шинжилгээний хурал, зөвлөгөөнийг тогтмол зохион байгуулж ирлээ. Түүнчлэн, хэрэгжүүлж буй бодлого, түүний хэрэгжилтийн байдалтай холбоотой бүхий л эрх зүйн баримт бичиг, журам, заавар, судалгааны ажил, тайлан, мэдээлэл, статистик мэдээ, хэвлэмэл бүтээгдэхүүнийг цахим хуудастаа байршуулан нийтэд танилцуулж байна.

7. Валютын ханшийн эрсдэлийг удирдах механизмыг Төв банкны болон банкуудын төвшинд хэрэгжүүлэх, санхүүгийн зах зээлийн оролцогчид болон экспортлогчид, импортлогчид валютын ханшийн эрсдэлээс хамгаалах чадавхийг бий болгох, гадаад улс, ОУ-ын байгууллагуудын хөнгөлөлттэй зээл, Засгийн газрын худалдан авалтыг хэрэгжүүлэх явцад ханшийн зөрүүгээс санхүүгийн хохирол учирсан тохиолдолд Засгийн газартай хамтран тодорхой бодлого, арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

Монголбанк шаардлагатай үед юанийн спот захад оролцох нөхцөлийг бүрдүүлэн ажилласны зэрэгцээ төгрөг-ам.доллар, төгрөг-юанийн своп, форвард хэлцлийг банкуудтай хийж байгаа нь валютын захын тогтвортой байдлыг хангах, банкуудын валютаар төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, спот захад үзүүлэх дарамт, ачааллыг бууруулах, ханшийн эрсдэлээс хамгаалах зэрэг ач холбогдолтой болж байна.

Монголбанк нь валютын зах зээлд оролцогчдын мэдлэгийг дээшлүүлэх, ханшийн эрсдэлээс хамгаалах арга, хэрэгслийг хэрэглэж хэвшүүлэх зорилгоор валютын своп, форвард хэлцлийн талаар аж ахуйн нэгжид зориулсан сургалтыг тогтмол зохион байгуулж, 2013 оны 5 дугаар сарын эцсийн байдлаар давхардсан тоогоор нийт 200 гаруй аж ахуйн нэгж

байгууллагын ажилтнуудыг сургалтад хамруулжээ. Үүний үр дүнд аж ахуйн нэгжээс банкуудтай санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан хэлцэл хийж, ханшийн эрсдэлээ бууруулах үйл ажиллагаа нэмэгдэж байна.

Валютын дотоодын захад санхүүгийн нэмэлт үйлчилгээ нэвтрүүлж, ханшийн эрсдэлийг удирдах механизмыг бий болгох үүднээс Монголбанк 2010 онд “Валютын своп, форвард хэлцлийн гэрээ, заавар”-ыг боловсруулан баталж, гадаад төлбөр тооцооны нэмэлт эрхтэй банкуудтай уг гэрээг байгуулсан бөгөөд эдүгээ Монголбанк болон банкууд хооронд своп, форвард хэлцлийг идэвхтэй хийдэг боллоо. Тухайлбал, банкууд Монголбанктэй өнгөрсөн онд нийт 1.6 тэрбум ам.долларын своп хэлцлийг хийжээ. Үүний үр дүнд төгрөг, валютын зах нь мөнгөний бодлогод нийцтэйгээр ажиллах боломж бүрдэж, банкууд илүүдэл нөөцөө удирдах, спот захад үзүүлэх дарамт, ачааллыг тодорхой хэмжээгээр бууруулах, арилжааг хугацааны хувьд тархаан байршуулах, банкны харилцагч ирээдүйн ам.долларын урсгалыг зохицуулах, ханшийн эрсдэлээс хамгаалах арга хэрэгсэлтэй болох боломжийг нээж өгсөн.

Гадаад худалдааны эргэлт нэмэгдэхийн хэрээр дотоодын компаниудын валютын захад оролцох оролцоо нэмэгдэж, валютын захад оролцож байгаа этгээд нь тодорхой хугацааны дараа валютын ханшийн эрсдэлээ удирдах үүднээс своп, форвард арилжааг харилцагч банкуудтай байгуулж эхлээд байна. Тухайлбал, Монголбанкнаас хэрэгжүүлж буй “Шатахууны жижиглэнгийн үнийг тогтворжуулах дэд хөтөлбөр”-ийн хүрээнд түлш шатахууны импортлогч компаниуд санхүүгийн үүсмэл хэрэгсэл ашиглан ханшийн эрсдэлийг бууруулан ажиллаж байгаа нь шатахууны үнэ төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн өөрчлөлтөөс хамаарч өсөхгүй байх суурь нөхцөл болж байна.

Монголбанк гадаад валютын улсын нөөцийн удирдлагыг бие даан хэрэгжүүлдэг бөгөөд энэ хүрээнд нөөцийн багцын эрсдэлийг хариуцан ажилладаг. Засгийн газрын худалдан авалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор үүсэх ханшийн эрсдэл нь Монголбанкны гадаад валютын улсын нөөцийн удирдлагад хамаарахгүй асуудал юм.

8. Бичил санхүүжилтийн өнөөгийн тогтолцоог боловсронгуй болгох, зээлийн батлан даалт, хадгаламжийн даатгалын тогтолцоо бий болгох.

Банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр эрхлэгчид батлан даалт гаргах сангийн үйл ажиллагааны зохистой хэм хэмжээг тогтоож, сангийн хэвийн, найдвартай ажиллах орчинг бүрдүүлэх чиглэлээр ажилласан. Мөн сангийн үйл ажиллагаанд хяналтын зөвлөлийн гишүүнчлэлээр дамжуулан оролцож, үйл ажиллагааг сайжруулах ажлыг зохион байгуулав.

“Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль” 2013.01.10-ны өдөр батлагдсантай уялдан Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайдын 2013.04.05-ны өдрийн 76/А-66 дугаар хамтарсан тушаалаар Хадгаламжийн даатгалын үндэсний хороог байгуулж, Хадгаламжийн даатгалын корпорацийг байгуулах ажлын нэгдсэн төлөвлөгөөг баталсан. Тус хорооны анхдугаар хуралдааныг 2013.04.11-ний өдөр зохион байгуулсан.

“Хадгаламжийн даатгалын корпорацийн дүрэм”, “Хадгаламжийн даатгалын үндэсний хорооны ажиллах журам”, “Хадгаламжийн даатгалын корпорацийн бүтэц, орон тоо ажил үүргийн хуваарь”-ийн төслийг Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хорооны төлөөллөөс бүрдсэн ажлын хэсэг боловсруулсан. Уг төсөл батлагдах шатанд байна.

Хадгаламжийн даатгалын шимтгэл хэлбэрээр банкуудаас татан төвлөрүүлэх хөрөнгийг Монголбанк дахь Засгийн газрын тусгай дансанд байршуулах ажил хэрэгжиж байна.